



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2015 оны 03 сарын 02 өдөр

Дугаар 02

Шарга

┌ Засаг даргын үйл ажиллагааны тайланг ┐
хэлэлцэж дүгнэх, үүрэг чиглэл өгөх тухай

Монгол улсын Засаг захиргаа, Нутаг дэвсгэрийн нэгж, Түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 /д/, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ИТХ-ын ээлжит IX хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1. Сумын засаг даргын 2014 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг Хангалттай гэж дүгнэсүгэй.

2. 2015 оны үйл ажиллагаандаа Иргэд, Төлөөлөгчдөөс гаргасан санал, санаачлагыг тусгаж ажиллахыг Сумын засаг дарга Д.Түмэнбаяр үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын нарийн бичгийн дарга Л.Сэрсмаа, Хороодын дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Ч.АЗБАЯР

